



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/260

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг томилох тухай**

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийг хувьчлах журам”-ын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үртсэн шахмал түлшний үйлдвэр ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, эд хөрөнгийн ашиглалтын байдалд шалгалт хийх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, шалгалтын ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Удирдамжийн дагуу хянан шалгалтыг гүйцэтгэж, холбогдох тайланг 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг /Д.Рэнцэнбямба/ -т даалгасугай.


3. Ажлын хэсгийн томилолтын зардлыг батлагдсан төсвийн дагуу олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-т зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
даргын 2019 оны 07 дугаар сарын 18 өдрийн  
1/260 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга	Д.Рэнцэнбямба – Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч
Нарийн бичгийн дарга	Ч.Мөнхбаяр – Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Гишүүд	Д.Төмөрбаатар – Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч Д.Итгэл – Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Н.Раднаасэд – Өмчийн хяналт, мэдээлэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Оюун-Эрдэнэ – Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
даргын 2019 оны 07 дугаар сарын 18 өдрийн  
1/2.60 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**“ҮРТСЭН ШАХМАЛ ТҮЛШНИЙ ҮЙЛДВЭР” ОНӨААТҮГ-ЫГ МЕНЕЖМЕНТИЙН ҮР  
ДҮНГ ХАРГАЛЗАН ХУВЬЧЛАХААР ШИЙДВЭРЛЭСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН ҮЙЛ  
АЖИЛЛАГАА, ЭД ХӨРӨНГӨД ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/21 дүгээр тогтоолоор Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгонд байрлах “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-ыг менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлахаар шийдвэрлэж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 45, 47 дугаар тогтоолоор “Менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын журам”, “Менежментийн гэрээний үлгэрчилсэн загвар” –тус тус батлагдсан. Журмын дагуу тендер шалгаруулалтыг зарлан явуулах буюу тендерийн хуваарийг батлах асуудалтай холбогдуулан тус үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай нарийвчлан танилцаж, судлах, санал боловсруулах үүрэгтэй Ажлын хэсгийн үйл ажиллагааг зохицуулахад удирдамжийн зорилго оршино.

**Хоёр. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1. Ажлын хэсэг үйлдвэрийн газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө нэг бүрийг нүд үзэж, нийслэлийн өмчийн бүртгэлийн систем дэх мэдээлэлтэй тулгалт хийнэ. Үүнд: газар, барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга, бусад үндсэн хөрөнгө, бараа материал гэх мэт.
2. Эд хөрөнгийн бүртгэл, ашиглалт хамгаалалтын байдалд үзлэг хийж, чанар байдлын талаар үнэлгээ өгнө.
3. Ажлын хэсэг үйлдвэрийн газрын авлага, өр төлбөрийг судалж, дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэнэ. /нийгмийн даатгал, татварын тайлан/
4. Сүүлийн 2-3 жилд аудитын байгууллагаас хийсэн санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын тайлан, зөвлөмжийг авч, судална.
5. Үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан Контракт гэрээний 3.16-д заасан “Үйлдвэрийн газрын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих хяналтыг зохион байгуулж, эд хөрөнгийн дотоодын тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу явуулж үнэн зөвийг хариуцна” гэсэн заалтын хэрэгжилтийг хянан үзнэ.
6. Газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг, газрын төлбөрийн төлөлтийг шалгана.
7. Маргаантай болон дутагдсан эд хөрөнгө байгаа эсэх талаар судална.

## Гурав. Хугацаа

Ажлын хэсэг 2019 оны 7 дугаар сарын 19 -ны өдрөөс 7 дугаар сарын 21-ний өдрийн хооронд Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгон дах "Үртсэн шахмал түлшний үйлдвэр" ОНӨААТҮГ –т ажиллаж, тайланг 7 дугаар сарын 24-ний дотор гаргана.

## Дөрөв. Үр дүн

1. Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах буюу хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын хуваарийг оновчтой боловсруулахад санал өгнө.

2. Хувьчлагдах хөрөнгийн зах зээлийн бодит үнэ цэнийг тогтоосон мэргэжлийн эрх бүхий байгууллагын үнэлгээний дүнд бодитой дүгнэлт өгч, улмаар гэрээний үнийг үнэн зөв тогтооход хувь нэмэр үзүүлнэ.

∞ ∞ ∞